



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.03.21 № 01/565  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ДАРГА НАРТ

*Улаанбаатар*  
*Нийгмийн даатгалын газар*  
*2024.03.29*

#### Чиглэл хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” А/34 дүгээр тушаалаар баталсан нийгмийн даатгалын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарийг хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн 2024 оны 3 дугаар сарын хуваарьт зардлын зүйл хооронд шилжүүлэн дараах зохицуулалтыг хийсэн болно. Үүнд:

1. Нийгмийн даатгалын байгууллагуудын цалин хөлс, урамшуулал, тогтмол зардлууд, хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшуулал, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж зэрэг зардлын төсөв хоорондын зохицуулалт;

2. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний буюу орон тооны бус төлөөлөгчийн зардлын төсвийн сар, улирлын хуваарийн өөрчлөлт;

Иймд дээрх зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг баримтлан төсвийн сахилга батыг хангаж ажиллахыг мэдэгдье.

ДАРГА *Ш.Мөнхзул* Ш.МӨНХЗУЛ



9024020135 CTC4666 9081730



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 дугаар сарын 18

Дугаар А/34

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн  
хуваарийг шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.13.1, 37.14.2, Сангийн сайдын 2024 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 39 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2.Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

3.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг төсвийг захиран зарцуулах эрх бүхий энэ тушаалын 1 дүгээрт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай” А/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХЗУЛ



